

хяналтад түшиглэн явуулах⁷⁷ тус тус болно.

2. Салбар эрх зүйн нэрлэсэн зарчмууд, хорих ялыг ялтны харьяалах орон нутагт эдлүүлэх үзэл санааг харгалзсан хорих ялыг ялтан “ялгамжтай нөхцөл бүхий салбар-хэсгүүдтэй”⁷⁸ Засан төлөвшүүлэх⁷⁹ нэг байгууллагад⁸⁰ (үүнийг гадаадын орнуудад “мульти” буюу “гибрид” зохион байгуулалттай) хорих ялыг эдлүүлэх эрх зүйн зохицуулалт, хууль зүйн практикийг нарийвчлан судалж манай оронд нэвтрүүлэн “нутагшуулах” асуудалд судлаачид төдийгүй салбарын байгууллага, хууль тогтоогч, “хууль хэрэглэгчдийн анхаарлыг нэн даруй хандуулж шийдлийг олох.

Өөрөөр хэлбэл ялтан хорих ялыг нэг байгууллага, түүний харьцангуй ялгаа бүхий нөхцөлтэй салбар-хэсэгт зан төлөвтэйгээ уялдан “шилжин эдлэх”⁸¹ зохицуулалт болно.

⁷⁷ Энэ үзэл санааг судлаач зарчмын хэмжээнд үнэлэх саналыг дэвшүүлж байна.

⁷⁸ Өнөөгийн ойлголтоор “ялгаа бүхий дэглэмтэй”

⁷⁹ Боловсролын тухай хуулийн 3.1.11-д “төлөвшил гэж суралцагчийн хүмүүжил, итгэл үнэмшлийн цогцыг ойлгоно” (www.meds.gov.mn) гэснийг харгалзан илтгэгч хорих ял эдлүүлэх байгууллагыг “Засан төлөвшүүлэх (сайжруулах) газар” гэж нэрлэхийг санал болгож байна.

⁸⁰ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 8-р зүйл “Янз бүрийн бүлгийн хоригдлуудад хүйс, нас, урьд ял шийтгэгдэж байсан эсэх, хоригдох болсон хууль зүйн шалтгаан болон тэдэнтэй харилцах зааврыг харгалзан тусдаа хорих газруудад эсхүл 1 хорих газрын өөр өөр хэсэгт байлгана”; ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 73-р зүйл “Хорих ял эдлүүлэх байгууллага”, 74-р зүйл “Засан хүмүүжүүлэх байгууллагын төрөл”.

⁸¹ ОХУ-ын хорих ял эдлүүлэх практикт үүнийг “социальный лифт” гэж нэрлэдэг.



М.ЦЭНД
ШШГЕГ-ын Хууль
тогтоомжийн
хэрэгжилт, дотоод
ажлын тасгийн дарга,
хурандаа

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Түлхүүр үг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын менежмент, мэргэжлийн ур чадвар, ялтны хөдөлмөр эрхлэлт, гэм хорын хохирол барагдуулалт, хөдөлмөрийн нөхцөл

Хураангуй

Хорих байгууллагын эрхлэх үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг зөв тогтоож, ялтныг ажлаар хангаснаар тэдний бусдад учруулсан гэм хорын хохирлыг барагдуулж, хөдөлмөрийн дадлага чадвар олгож, суллагдсаны дараа нийгэмд зөв амьдрах хэвшилтэй болгох юм. Нөгөө талаасаа тэдний ажиллах хүч, хөдөлмөрлөх чадварыг дайчлан эх орны бүтээн байгуулалтад бодитой хувь нэмэр оруулж, материаллаг баялгийг бүтээж болно.

Менежмент гэдэг нь та яг юу хийхийг хүсэж байгаагаа олж мэдээд хамгийн шилдэг хүнээр хамгийн хямдаар хийлгүүлэх урлаг юм. **Ф.В.Тейлор**

Аль ч улс орны оршин тогтнохын нэг үндэс бол хөдөлмөр байдаг. Учир нь хүний нийгмийн материал, соёлын

бүх үнэт зүйл хөдөлмөрийн үр дүнд бий болдог. Нийгмийн амьдралд хүнийг бүх талаар нь төлөвшүүлэн хөгжүүлэх, амьдрах нөхцөлийг нь дээшлүүлэх чухал хүчин зүйл нь хөдөлмөр юм.

Хөдөлмөр бол хүн төрөлхтний нэн тэргүүний үндсэн нөхцөл юм ⁸². Хөдөлмөр хүмүүсийн бүх талын хөгжлийг хангах хэрэгсэл, нийгмийн амьдралыг цогцлоох хүчин зүйл болохоос гадна бусдыг хүндэтгэх, сахилга, дэг журмыг сахих, хариуцлагаа ухамсарлах зэрэг шинж чанаруудыг хүмүүст төлөвшүүлдэг.

Хорих ял эдлэгч хөдөлмөр эрхэлснээрээ бусдад учруулсан гэм хорын хохирлоо барагдуулах, өөртөө мөнгөн хуримтлал бий болгох боломж бүрддэг. Хөдөлмөр эрхлэх явцад тэдний бие махбод чийрэгжихийн зэрэгцээ гэмт үзэл бодол нь эерэгээр солигдож хүмүүжлийн төлөвшил олоход чухал нөлөө үзүүлдэг байна. Оросын алдарт сурган хүмүүжүүлэгч А.С.Макаренко “Хүн зөвхөн хамтын хөдөлмөрт оролцсоноор л бусад хүмүүст хандах ёс суртахууны төлөвшил олж авдаг” ⁸³ гэжээ.

Хорих байгууллагын үйлдвэрлэл, ялтнаар хөдөлмөр эрхлүүлэх тухай асуудал нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын менежментийн анхаарвал зохих чиглэл болоод байгаа юм.

Санаатай болон санамсар болгоомжгүй байдлаар гэмт хэрэг үйлдэж, олон нийтээс тусгаарлагдан

хорих ял эдэлж байгаа хүмүүсийг нийгэмшүүлэх, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэхэд хөдөлмөрийн үр нөлөө асар их болохыг манай байгууллагын түүх харуулдаг. Хорих байгууллагын эрхлэх үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг зөв тогтоож, ялтныг ажлаар хангахад төрөөс зохих анхаарал тавьж ирсэн нь энэ чиглэлээр удаа дараа гаргаж байсан эрх зүйн актуудаас харагдаж байна. Эдгээрээс дурдвал 1929 оны 06-р сарын 14-нд Засгийн газрын 09-р хурал, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 55 дугаар хурлаар баталсан “Аливаа хэрэгтэн ялтнаар ажил үйлдвэрлэл хийлгэх тухай дүрэм”, 1960 оны 3 дугаар сарын 2-ны өдөр БНМАУ-ын СнЗ-өөс баталсан “Засан хүмүүжүүлэх байгууллагын үйлдвэрийн чиглэлийг тогтоох тухай” 86 дугаар тогтоол, СнЗ-өөс 1967 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр баталсан “Засан хүмүүжүүлэх байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 98 дугаар тогтоол, МАХН-ын Төв Хорооны 1980 оны 206, мөн оны СнЗ-ийн 413 дугаар тогтоол зэрэг олон эрхийн актууд гарч, ялтныг уул уурхай, мод, модон материал бэлтгэл, барилга байгууламж, барилгын материал үйлдвэрлэл, газар тариалан, зам тавих зэрэг эх орны бүтээн байгуулалтын бүх салбарт ажил хөдөлмөр эрхлүүлж, хөдөлмөрийн үр нөлөөг ялтнуудад ухамсарлуулах, нийгэмшүүлэх, хөдөлмөрийн дадал чадвар олгох томоохон зорилтуудыг цогцоор нь шийдвэрлэж байлаа. Жишээлбэл: Хүүхдийн 1 дүгээр эмнэлэг, ИШГЕГ, ТЕГ, Улсын багшийн их сургуулийн байрууд, Улсын дээд шүүхийн өргөтгөл, ХСИС-ийн

⁸² К. Маркс, Ф.Энгельс “Түүвэр зохиол” III боть Улаанбаатар 1971 74-р хуудас

⁸³ Макаренко А.С. Сочинение. Т 4. Стр 397

цогцолбор ажигчдын орон сууцны хамт, Улаанбаатар хотын бага тойргийн орон сууцнууд, Толгойт, Хүүшгийн ам, Баянзүрх дэх ногоон зоориуд, Хүрэлтогоот, Дамбадаржаа дахь 150-200 мянган⁸⁴ тонны багтаамжтай мөсөн зоориуд гэх мэт барилгын салбарын бүтээн байгуулалт, Бугант, Ерөө, Бат-Өлзийт, Хархорин, Бэрлэг, Мөнгөнморьт, Багануур зэрэг газарт мод бэлтгэл, модон материалын үйлдвэрлэл эрхэлж жилдээ 240-300 мянган куб метр мод, 15-20 сая төгрөгний зам барьж, Бороо, Цагаанчулуутын алтны уурхай жилдээ 50-75 кг алт олборлож⁸⁵, Их хайрханы вольфрам, Хар айраг, Хажуу улааны жонш 35000-40000 тонн, Бодончийн гялтгануур, Харчулуутын гянтболд, Цагаан-овоогийн альбастр, Налайх, Ганц мод, Төгрөг, Мөрөнгийн нүүрс, Гачууртын чулуу, Мааньтын шохой, Авдрантын боржин чулуу олборлох зэрэг олон тооны уул уурхайн үйлдвэрлэл, Увс, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын нутагт газар тариалан, Буйр нуурт загасны үйлдвэр, Налайх-Хонхорын төмөр замыг барьж, Д.Сүхбаатарын хөшөөг ялтан зураач, архитекторч С.Чоймбол⁸⁶ бүтээн байгуулжээ.

Хорих байгууллага улсын төвлөрсөн төлөвлөгөөг байнга 100-аас дээш хувь давуулан биелүүлж, жилдээ 110-128 сая төгрөгийн үйлдвэрлэл явуулж

байснаас гадна тухайн үеийн ЗХХБ-н алба хаагчдын цалин хөлс, ялганы бүх зардлыг хариуцан гаргадаг байлаа. 1976-1980 оны төлөвлөгөө буюу 6 дугаар таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь 22 хоногийн өмнө 100,4 хувиар давуулан биелүүлж 584 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 440 сая төгрөгний борлуулалт хийж, 99 сая төгрөгний ашигтай ажиллаж, 7 дугаар таван жилийн төлөвлөгөөг ч 107,5 хувиар давуулан биелүүлж байлаа.⁸⁷

Хорих байгууллага нь ялганыг хөдөлмөрлүүлэхийн зэрэгцээ мэргэжилтэй ажилчин бэлтгэх, төрөл бүрийн мэргэжилд сургахад гол анхаарлаа хандуулж байв. Хорих ял эдлэгсдийн дундаас гавьяат, алдартнууд, хөдөлмөрийн суутнууд олноор төрөн гарсан билээ. Тухайлбал: Улсын баатар Дандар, Хөдөлмөрийн баатар, тэмээчин Маань, тариаланч Цэрэнчимэд, Бямбацогт, адуучин Ичинхорлоо, жолооч Загд, Ардын жүжигчин Дамдинсүрэн, гавьяат жүжигчин Батзаяа, Лувсанжамц, Лхагваа, гавьяат барилгачин Эмээлт, гавьяат агрономич С.Ганболд, соёлын гавьяат зүтгэлтэн С.Бирваа⁸⁸, уран барималч Чоймбол, Ардын уран зохиолч Б.Ринчин, Төрийн шагналт зохиолч Ч.Чимид, зохиолч Чойном⁸⁹, МАХН-ын УТТовчооны гишүүн, СнЗ-н орлогч дарга Рагчаа, АИХ-ын орлогч дарга

⁸⁴ А.Лхагваа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл байгууллагын түүхэн замнал” УБ. 2011.380 хуудас

⁸⁵ А.Лхагваа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл байгууллагын түүхэн замнал” УБ. 2011.148 хуудас

⁸⁶ Мөн тэнд 149 дүгээр хуудас

⁸⁷ “Засан хүмүүжүүлэх албаны мэдээлэл сэтгүүл” 1981 №2 15 дахь тал

⁸⁸ А.Лхагваа “Монгол Улсын ШШГБ-н түүхэн замнал” УБ 2011 165 хуудас

⁸⁹ “Тэргүүн” сонин 2007. 02 сар №4/116/

Лоохууз⁹⁰, Ардын боловсролын тэргүүний ажилтан Найдан зэрэг олон хүнийг дурдаж болно.

ЗХХБ-н ахмад ажилтан, бэлтгэл хурандаа Дэндэвийн Аварзэд гуай дурсамжиндаа: “ЗХХБ манай улсын үйлдвэр аж ахуйн бараг бүх салбарын эх үндсийг тавьсан юм шүү дээ. Социализмын үеийн үзэл суртлын явцуурлаас болоод улс орны эдийн засгийн гол салбаруудын үндэс суурийг засангийнхан тавьсан болчих гээд байсан тул энэ үнэнийг дурддаггүй байсан. Онон, Хараа, Ерөө, Жаргалант гээд САА-н тулгын чулууг засангийнхан тавьсан, гар үйлдвэрлэл эрхэлж, алт олборлож, байшин барьж, мөн ч их зүйл бүтээсэн дээ” хэмээн өгүүлжээ.⁹¹

Ялтнаар хөдөлмөр эрхлүүлэх хууль эрх зүйн зохицуулалтын талаар дурдвал:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” Монгол Улсын хуулийн 120 дугаар зүйлд “Ялтны хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөл”, 121 дүгээр зүйлд “Ялтны хөдөлмөрийн хөлс”, ШШГЕГ-н даргын 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдөр А/33 дугаар тушаалаар батлагдсан “Ялтныг гэрээгээр ажиллуулахад мөрдөх заавар”, 2008 оны А/115 дугаар тушаалаар батлагдсан “Ялтныг мэргэжлийн түр сургалтанд хамруулах, шалгалт авах, мэргэжлийн чадамжийн гэрчилгээ олгох журам”, 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдөр А/32 дугаар тушаалаар батлагдсан “Ялтны

хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох журам”, 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр А/156 дугаар тушаалаар батлагдсан “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр” зэрэг болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 07-р сарын 15-ны өдрийн 156 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийн 3.6 дахь хэсэгт: “Үйлдвэрлэлийг хөгжүүлэн үйл ажиллагааных нь үр дүнд хорих ял эдлэгчийг ажлын байраар хангах, хорих анги, салбар нэгжийг түшиглэсэн үйлдвэр, үйлдвэрлэх бүтэгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар дотоод эх үүсвэрийг бий болгох” тухай, мөн тушаалын 3-р хавсралтад “Хорих ангиудын дэргэд олон улсын жишиг үйлдвэрийн байр барих”, “Үйлдвэрлэлийг өргөтгөж, бизнесийн дотоод сүлжээг байгуулах, ялтныг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах”, “Ялтны хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар цогц арга хэмжээ төлөвлөн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах /засгийн газарт санал оруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн орлогоос хохирогчийн хохирол аль болох иуурхай нөхөн төлөгдөх нөхцөлийг бүрдүүлэх”, “эрчимжсэн мал аж ахуй ба газар тариалан төсөл хэрэгжүүлэх” тухай тус тус заасан байна.

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь анхаарал

⁹⁰ Ц.Лоохууз “Хол гишгэж ойр харж явья” /Эмхэтгэгч С.Баатар/ УБ. 2006 132 хуудас

⁹¹ “Эрх зүй албаны мэдээлэл” сэтгүүл 1996 №2

хандуулж, тодорхой ажил зохион байгуулж байгааг баримтаар дурдвал:

ШШГЕГ нь 2014 онд 2585 тн шохой, 5850 тн шохойн чулуу, 980,000 улаан тоосго, 2077 м² вакум цонх, хаалга, 168106 ширхэг чулуун бүтээгдэхүүн, 29000 ширхэг нүхтэй блок, 3118 м³ хөнгөн блок, 1060 тн эрдэст нунтаг зэрэг 3,180,6 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2229,5 сая төгрөгийн борлуулалт хийжээ.

Мөн онд 4375 ялтныг ажлын байраар хангаснаас 2171 ялтан тогтмол ажиллаж, 1378,7 сая төгрөгийн цалинг ялтануудад тооцон олгожээ. Хөдөлмөр эрхэлсэн ялтан өмнөх оныхоос 0,1 хувиар, цалин бодолт 0,8 хувиар өсөж, шүүхийн төлбөр буюу гэм хорын хохиролд 1643 ялтны 296,0 сая төгрөг төлж барагдуулсан нь 2013 оныхоос 53 хувиар өссөн байна.

2015 онд 2960 ялтанг ажлын байраар хангаж, 446,9 сая төгрөгийн цалин бодогдсон байна. Ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгасан шүүхийн төлбөрт ялтны 88.2 сая төгрөг шилжүүлэн барагдууллаа.

Хорих 409 дүгээр ангид “Гутлын үйлдвэр” байгуулахаар судалгаа хийгдэж дууссан ба БНХАУ-ын Венжоу хотын “Венжоу Импорт Экспорт” компанитай гэрээ байгуулж, 2015 оны 2 дугаар улиралд багтаан ашиглалтанд оруулсан. Уг үйлдвэр нь жилдээ 8,0-10,0 мянган ширхэг хос гутал хийх хүчин чадалтай ба үндсэн бүтээгдэхүүн нь ялтны ажлын гутал, албан хаагчдын хагас түрийтэй гутал байхаар төлөвлөж, өнөөдрийн байдлаар

Хорих 409 дүгээр ангид гутлын шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулан туршилтын журмаар албан хаагчдын хагас түрүүтэй гутал 100 хос, албаны хагас түрүүтэй өвлийн гутал 100 хос, ялтны ажлын гутал 100 хос, нийт 300 хос гутал үйлдвэрлэн үйлдвэрийн үйл ажиллагааг жигдрүүллээ.

Дархан-Уул аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албанд эсгийний үйлдвэр шинээр байгуулсан бөгөөд одоогийн байдлаар 6 метрийн урттай 2 метрийн өргөнтэй нийт 22 ширхэг эсгийг үйлдвэрлээд байгаа ба нэг эсгий дунджаар 17-18 кг ахрын ноос, 5-6 кг ноосны очоос хийн бутлагч, эргүүлэгч машин ашиглан үйлдвэрлэж байна.

Хорих 407 дугаар ангид 2 үйлдвэрийн цехэд 80 ялтныг тогтмол ажлын байраар хангаж, цэргийн дүрэмт хувцас, ялтны нормын хувцас хэрэглэлийг оёж байна. Энэ үйлдвэр нь өдөрт 20-120 хос хувцас, гэрийн цагаан бүрээс 350-400, цагаан хэрэглэл 500-550 хосыг үйлдвэрлэх хүчин чадалтай юм. Энэ онд 12 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж 90,623,0 төгрөгийг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 20 орчим нэгжид бүтээгдэхүүн үйлдвэрлэл явагдаж 2,512,5 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2,012,0 сая төгрөгний борлуулалт хийсэн хэдий ч зарим шалтгааны улмаас төдийлөн жигд ажиллаж чадахгүй байна. Мөн ихэнх нэгжид үйлдвэрлэлээ өргөжүүлэх, шинээр үйлдвэр байгуулах санал их байгаа тул энэ асуудлыг шийдвэрлэхээр Үйлдвэр, хөдөө аж

ахуйн яамтай зөвшилцөн тодорхой тооны жижиг, дунд үйлдвэрийн төслийн зээлийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлхээр хандаад байгаа юм.

Энэ ажлын хүрээнд эхний ээлжинд хэрэгжүүлэх боломж бүхий 14 нэгжийн 6,8 тэрбум төгрөгийн жижиг, дунд үйлдвэрийн төслийг шалгаруулж, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яаманд хүргүүлээд байна. Үүнд,

-Байгалийн болон хиймэл чулуу хийх үйлдвэр;

-Хаягдал цаас дахин боловсруулж, цаасан уут хийх үйлдвэр;

-Машины гупер, гэрлийн үйлдвэр;

-Гутлын үйлдвэр;

-Гурилын үйлдвэр;

-Гар нүүр, биеийн алчуурын төсөл;

-Оёдлын үйлдвэрийн өргөтгөлийн төсөл;

-Хагас боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл;

-Гэрийн бүрээс үйлдвэрлэх төсөл;

-Хөнгөн блокны үйлдвэрлэлийн төсөл;

-Вакум цонхны үйлдвэрлэлийн төсөл;

-Блок үйлдвэрлэх төсөл;

2015 онд албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч БЗД-ийн 16 дугаар хороонд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын 160 айлын орон сууц, Сүхбаатар аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагчдын 16 айлын орон сууц, Цагдан хорих 461 дүгээр ангийн албан хаагчдын хүүхдийн цэцэрлэгийн барилга зэргийг ашиглалтад орууллаа.

“Монгол улсын засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-т заасан:

-Ажлын байр шинээр бий болгох хөтөлбөр хэрэгжүүлэх;

-Барилгын материалыг эх орондоо үйлдвэрлэдэг болох;

-Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдэд үндэсний аж ахуйн нэгжүүд давуу эрхээр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх, туслан гүйцэтгэгчээр ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

-Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх зорилго бүхий хөдөө аж ахуйн биржийг байгуулах, импортоор оруулдаг хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, төмс, хүнсний ногоо, сүү, өндөгний хэрэгцээг дотооддоо хангадаг болох;

-Хүнсний нарийн ногооны тарналалтыг нэмэгдүүлж дотоодын хэрэгцээг хангах;

-Аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих;

-Боловсруулах үйлдвэр байгуулан Монгол Улсад олборлож байгаа ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрт эхний ээлжид нийлүүлдэг болох;

-Улсын Их Хурлаас баталсан “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот” хөтөлбөр, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан төмөр замыг барьж байгуулах ;

-Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах зэрэг зорилт хөтөлбөрүүдэд Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх байгууллага томоохон үүрэг гүйцэтгэж чадна.

Төмөр зам, авто зам, гүүр барих, уурхай олборлох, ашигт малтмалын хайгуул хийх, газрын тос, төмрийн хүдэр болон бусад ашигт малтмал боловсруулах, хог хаягдал боловсруулан эрчим хүч гаргах үйлдвэр, нарны цэнэгээр халаах төхөөрөмжийн үйлдвэр байгуулах, барилгын материал үйлдвэрлэх зэргээр төрөл бүрийн үйлдвэрлэл эрхлэх боломжтой, чадвартай юм. Энд ганцхан зохицуулалт хэрэгтэй. Энэ нь төрөөс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг тодорхой чиглэлийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах тухай шийдвэр гаргах асуудал юм.

Германы “Дойче Велле” агентлагийн мэдээлснээр: “Герман улс ялтнуудын хүчээр жилд 200 сая маркийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг ба volkswagen автомашины үйлдвэр, ikea, aidl зэрэг концернуудад ажилладаг” байна.⁹²

Америкийн нэгдсэн улсын хорих ангиуд Motorola, Compaq, Honeywell, Microsoft, Boeing, Nortel⁹³ зэрэг компаниудад ажиллаж жилдээ 398 саяас 1 тэрбум 31 сая долларын үйлдвэрлэл эрхэлдэг гэнэ.⁹⁴

Оросын холбооны улсын төрийн думын гишүүн Александр Хинштейн “Хорих ял эдлүүлэх тухай” хуульд “Ялтныг хорих ангийн байрлалаас гадуур, төрийн болон хувийн хэвшлийн үйлдвэрлэлд хөдөлмөр эрхлүүлэх”

нэмэлт өөрчлөлт оруулах санал оруулжээ. Энэ санал зөвшөөрөгдвөл хорих ангиас хэдэн зуун километр алслагдсан бүсэд хөдөлмөр эрхлэх боломж олгох юм. Мөн тэрээр 2018 онд дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах цогцолбор барих, Сочи хотын эргэн тойрны ойг цэвэрлүүлэх, Керченскийн буланд гүүр тавих зэрэг бүтээн байгуулалтад оролцуулах төлөвлөгөө боловсруулан Төрийн думд өргөн барьжээ.⁹⁵

Хорих ял эдлэгсдийг хөдөлмөрт хамруулан, тэднийг ажлын байраар тогтмол хангах нь нэг талаас тэднийг нийгэмшүүлэх, гэмт хэргийн замаар буюу амар хялбар аргаар мөнгө олох, хүсэл сонирголоос татгалзуулах, ажил хөдөлмөрийн үр шимийг мэдрүүлэх, хөдөлмөрийн хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх, ажил хөдөлмөр эрхлэх дадлага чадвар бий болгох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, бие бялдрыг эрүүлжүүлэх, нөгөө талаас эх орны бүтээн байгуулалтын ажилд томоохон, бодитой хувь нэмэр оруулах, эдийн засгийн хэмнэлт гаргах ач холбогдолтой юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын менежментийн шинэчлэл нь:

-Хорих байгууллагын дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэхээс гадна ялтны хөдөлмөрийг улс орны бүтээн байгуулалтад түлхүү оролцуулах замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, нөгөө

⁹² Deutsche Welle | 15 января 2014, 09:37 delfi

⁹³ kommersant.ru/doc/2430878

⁹⁴ Вопросик 23 июля 2015 svargaman

⁹⁵ Новая газета, 2015

талаар улсын эдийн засагт тодорхой хэмнэлт, үр ашгийг бий болгох

-Бүтээн байгуулалтын ажилд оролцож болох чиглэлийн талаар судалгаа хийх

-Гэм хорын хохирлыг тэдний хөдөлмөрийн хөлснөөс нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх

-Ялтныг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэг хэлбэр нь хөдөлмөрийн хүмүүжил буюу хөдөлмөрийн дадлага чадвар олгох явдал юм. Хөдөлмөр эрхэлснээр ажлын эв дүй, арга ухаан, тэсвэр хатуужил, хамт олны дунд биеэ зөв авч явах дадал хэвшил суухаас гадна суллагдан гарсны дараа нийгэмд эзлэх байр сууриа олоход дөхөм болно. Үүний тулд ялтныг хөдөлмөр эрхлүүлэх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь ШШГБ-ын менежментийн шинэчлэлийн нэг чухал асуудал юм.



Г.БАТТУЛГА

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн ахлах багш, хошууч

ГЭРЧ, ХОХИРОГЧ ХАМГААЛЛЫН ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэгдсэн үндэстний байгууллагаас 1948 онд батласан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйлд: “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр хамгаалуулах эрхтэй”⁹⁶ гэж заажээ.

Мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалыг батлан гаргаснаар олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болсон байна. Уг тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”-ыг улсуудад уриалсан⁹⁷.

⁹⁶ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <http://www.legalinfo.mn/law/downloadPdf/1271/>

⁹⁷ М.Ичинноров. “Гэрч, хохирогчийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах тогтолцоо бий болж байгаа нь эрх зүйн шинэтгэлийн чухал алхам мөн” Хууль сахиулахын инноваци олон улсын эрдэм шинжилгээний бага хурал дээр тавьсан илтгэл <http://ichinnorovm.blogspot.com/2014/11/blog-post.html>